

Кодын бүтэц

01	01	10	00
БҮЛЭГ			ҮНДЭС НИЙ КОД
ЗҮЙЛ			
МӨР			
УЯЛДУУЛСАН СИСТЕМИЙН КОД (HS CODE)			

0101.10.00 Цэвэр үүлдрийн үржлийн мал



МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

Танд лавлах зүйл байна уу!



1800-1281

Гааль сонсож байна



Талархал



Гомдол



Асуулт



Санал

ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор “Гаалийн лавлах-1281” нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.



Хаяг:
Сүхбаатар дүүрэг, “Их тойруу-81/1”,
Улаанбаатар-14193, Монгол Улс
Утас: (976-11) - 350049
Факс: (976-11) - 350048
E-mail: info@customs.mn
Интернет: <http://www.customs.gov.mn>

“БАРААГ ТОДОРХОЙЛОХ, КОДЛОХ УЯЛДУУЛСАН СИСТЕМ”-ИЙН ТУХАЙ



УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

"Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"

Дэлхийд өрнөж буй үйл явц нь улс орнуудыг гадаад худалдаанд зохицуулалт хийх, барааны урсгалыг хяналтандаа авах, ялангуяа олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдаж байгаа стратегийн ач холбогдол бүхий барааны хөдөлгөөнд тавих хяналтыг сайжруулах шаардлага зэргээс үүдэн Дэлхийн гаалийн байгууллагаас 1983 онд "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн тухай Олон Улсын конвенцийг баталсан.

БТКУС-ийг Конвенцийн 155 хэлэлцэн тохирогч тал, 200 гаруй улс орон, мөн эдийн засгийн болон гаалийн холбоод гаалийн тарифын болон тарифын бус арга хэмжээг тогтоох, олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээр хийх, зарим нэр төрлийн барааг гаалийн татвараас чөлөөлөх, гаалийн хөнгөлөлт үзүүлэхэд ашиглаж байна.


Дэлхийн гаалийн байгууллагаас эмхтгэн боловсруулсан уг конвенци нь Удиртгал, 20 зүйл, Уялдуулсан систем /УС/-ийн Жагсаалт, УС-ийн Ерөнхий тайлбар дүрэм, хэсэг, бүлэг мөрийн тайлбар бүхий хавсралтаас бүрддэг.

Одоогийн байдлаар дэлхийн худалдааны эргэлт дэх барааны 98%-ийг энэ системийн дагуу ангилж байгаа нь олон улсын худалдааны хууль ёсны суурь ангилал болоод байна.

Дэлхийн гаалийн байгууллагаас Уялдуулсан системийн Жагсаалтад 4-6 жилийн хугацаанд нэмэлт, өөрчлөлт оруулдаг. Гадаад худалдаан дахь барааны бүтэц нь нийгмийн хөгжил, техникийн дэвшил, эрэлт хэрэгцээг дагаад байнга өөрчлөгддөг. Эдгээр өөрчлөлтүүд нь шинэ бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, олон улсын худалдаан дахь бараа эргэлт, нийгэм болон хүрээлэн буй орчинд аюул, хор хохирол учруулж болох бараа бүтээгдэхүүнтэй холбоотой байдаг ба барааны ангиллыг тодорхой болгох, хэллэг, найруулгыг боловсронгуй болгоход чиглэгддэг. Өнөөдрийн байдлаар Уялдуулсан системд 1992, 1996, 2002, 2007,

2012, 2017 онуудад буюу нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт ороод байна.

Монгол Улс Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн тухай Олон улсын конвенцид 1991 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр нэгдэн орж, 1993 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэн нь дэлхийн хамтын нийгэмлэгийн хүрээн дэх даяарчлалын үйл явцад хөл нийлүүлэн хөгжих, гадаад худалдаанд идэвхитэй оролцох алхам болсон.



Манай улс Уялдуулсан системийг дараах зорилгоор хэрэглэж байна. Үүнд:

- үндэсний тарифын тогтолцоо бүрдүүлэх;
- тарифын бус арга хэмжээг тогтоох;
- гадаад худалдааны гаалийн статистик мэдээ гаргах;
- олон улсын худалдааны гэрээ, хэлэлцээр хийх;

-зарим нэр төрлийн барааг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх гэх мэт.

Гаалийн байгууллагын цахим хуудас (customs.gov.mn)наас Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системд үндэслэсэн гадаад худалдааны барааны ангиллын жагсаалтыг харж болно.

"Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн бүтэц, зохион байгуулалт



"Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн жагсаалт

Зүйл	Мөр (HS code)	Үндэсний код	Барааны бичиглэл	Хэмжих нэгж
01.01	0101.10	10	Амьд адуу, илжиг, луус болон хөдий луус. -Цэвэр үүлдрийн үржлийн мал -Бусад	толг
	0101.90	00		толг